

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

2025.12.19

**Нэг. Хяналт-шинжилгээний зорилго**

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор хяналт-шинжилгээг хийсэн.

**Хоёр. Хяналт-шинжилгээний арга зүй**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу тус газрын Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтэс нь байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэж, Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлсэн. Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээг гүйцэтгэсэн. Хэрэгжилтийг дүгнэхдээ журмын 2.4-т заасан аргачлалын дагуу дүгнэж, 2.5-д заасан ангилалд шилжүүлэн тооцон гаргасан болно.

**Гурав. Хяналт-шинжилгээний дүн**


Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 62 (82 шалгуур үзүүлэлт) үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний 2.4, 2.13, 2.20, 4.3, 4.9, 4.13 -т тусгасан ЗНУХ, НЭМӨХСХ (Нийтийн эрүүл мэндийн өвчний хяналт, сэргийлэлтийн хэлтэс), ЭТХ-ийн хариуцан хэрэгжүүлэх 6 ажил (6 шалгуур үзүүлэлт) нь төлөвлөгөө батлагдсаны дараа дээд шатны байгууллагуудаас гаргасан захирамж, тушаал шийдвэр болон ЗГ-ын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн "Төсвийн хэмнэлтэд тооцох тухай" 02 дугаар тогтоолын улмаас цаашид хэрэгжих боломжгүй болсон тул хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас хасаж тооцсон байна.

Тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаас 46 ажил буюу нийт ажлын 82.2%-нь 85 түүнээс дээш хувийн хэрэгжилттэй, 6 ажил буюу 10.7% нь 70-85 хувийн хэрэгжилттэй, 4 ажил буюу 7.1% нь 70 хүртэл хувийн хэрэгжилттэй байгаа ба НЭМГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 92.2% буюу "бүрэн хангалттай" гэж үнэлэгдэв.

Хүснэгт 1. Хяналт-шинжилгээний чанарын үзүүлэлт

| Үнэлгээ                                                                                                                                                                                                                                                            | Арга хэмжээ |            |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|------------|
|                                                                                                                                                                                                                                                                    | Тоо         | Эзлэх хувь |
| <b>85 хувь буюу түүнээс дээш хувь</b> бол "бүрэн хангалттай"<br>(арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн) | 46          | 82.2%      |
| <b>70-85 хувь</b> бол "хангалттай"<br>(шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах)                                                                                                                             | 6           | 10.7%      |
| <b>70 хүртэл хувь</b> бол "хангалтгүй"<br>(удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотлогдсон.)                                                                                                          | 4           | 7.1%       |
| Нийт                                                                                                                                                                                                                                                               | 56          | 100%       |
| Дундаж                                                                                                                                                                                                                                                             |             | 92.2%      |

График 1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн эзлэх хувь




Хүснэгт 2. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн Төлөвлөгөөний хэрэгжилт (хариуцсан нэгжээр)

| №  | Хэлтсийн нэр             | 2025 онд төлөвлөсөн нийт ажил | Төлөвлөгөөнд эзлэх хувь | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь |         |            | Хэрэгжихгүй болсон арга хэмжээ* |
|----|--------------------------|-------------------------------|-------------------------|---------------------------------|---------|------------|---------------------------------|
|    |                          |                               |                         | 85% түүнээс дээш                | 70%-85% | 70% хүртэл |                                 |
| 1. | ЗНУХ (ЗТУХ+СХОХ)         | 33                            | 53.2%                   | 26                              | 3       | 1          | 3                               |
| 2. | ЭТХ                      | 8                             | 12.9%                   | 6                               |         | 1          | 1                               |
| 3. | НЭМӨХСХ (ЭМДХБӨХ+НЭАХӨХ) | 13                            | 21%                     | 8                               | 2       | 1          | 2                               |
| 6. | ЭМХХ                     | 3                             | 4.8%                    | 3                               |         |            |                                 |
| 7. | ХШҮДАХ                   | 4                             | 6.5%                    | 3                               |         | 1          |                                 |
| 8. | Ажлын хэсэг              | 1                             | 1.6%                    |                                 | 1       |            |                                 |
|    | Нийт                     | 62                            | 100%                    | 46                              | 6       | 4          | 6                               |

\*2025 онд дээд шатны байгууллагуудаас гаргасан захирамж, тушаал шийдвэр болон ЗГ-ын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн "Төсвийн хэмнэлтэд тооцох тухай" 02 дугаар тогтоолын улмаас хэрэгжихгүй боломжгүй болсон арга хэмжээ.

График 2. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн

төлөвлөгөөний биелэлтийн хувь (хариуцсан нэгжээр)



### Дөрөв. Дүгнэлт

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 92.2%-ийн хэрэгжилттэй байна. Төлөвлөгөөнд 62 ажил батлагдсанаас 6 ажил дээд шатны байгууллагуудаас гаргасан захирамж, тушаал шийдвэр болон ЗГ-ын 2025 “Төсвийн хэмнэлтэд тооцох тухай” 02 дугаар тогтоолын улмаас хэрэгжихгүй болсон байна. Тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаас 46 ажил буюу нийт ажлын 82.2%-нь 85 түүнээс дээш хувийн хэрэгжилттэй, 6 ажил буюу 10.7% нь 70-85 хувийн хэрэгжилттэй, 4 ажил буюу 7.1% нь 70 хүртэл хувийн хэрэгжилттэй байна. 70 хүртэл хувь буюу хэрэгжилт хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай 4 ажлыг дурдвал:

- 2.9 дэх ажил - Нийтийн эрүүл мэндийн өвчний хяналт, сэргийлэлтийн хэлтэс,
- 2.14 дэх ажил – Эмнэлгийн тусламжийн хэлтэс,
- 3.9 дэх ажил – Төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
- 5.2 дахь – Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтэс.
- Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн гүйцэтгэл 92.2% байгаа нь “бүрэн хангалттай” гэж үнэлэгдэв.
- Зарим арга хэмжээний төлөвлөлт утга агуулгын давхардал үүссэн, 1 арга хэмжээг олон задалж төлөвлөсөн байна. Тухайлбал, төлөвлөгөөний 3.13-3.16-д нийт 4 удаа “Төрийн албан хаагчийн ёс зүйтэй” холбоотой асуудлыг төлөвлөсөн. 3.17-3.18-д “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, байгууллагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх” арга хэмжээг тус тус тусгасан байна.
- Хэрэгжилт хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай 1 үйл ажиллагаа нь харьяа эрүүл мэндийн байгууллагын төсөв, санхүүгийн асуудлаас шалтгаалсан байна.

### Тав. Зөвлөмж

1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 онд хамтран ажиллах гэрээ, Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-

2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2026 онд хөгжүүлэх төлөвлөгөөнд нийцүүлэн оновчтой зөв тодорхойлох.

2. Бодлогын баримт бичиг, хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн салбарын хэрэгжүүлэх үйл ажиллагааг газрын болон хэлтсийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, улмаар тусгасан эсэхэд хэлтсийн дарга нар хяналт тавьж ажиллах.
3. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээний дүнгээр хэрэгжилт хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай 3 ажил бодлогын баримт бичиг, нийслэлийг хөгжүүлэх төлөвлөгөөнд тус тус тусгагдсан тул 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, үйл ажиллагааг эрчимжүүлэх.
4. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.2-т тусгасан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх ажлыг газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дахин тусгаж, хэрэгжүүлэх, улмаар, хэлтсийн төлөвлөгөө болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг сайжруулж ажиллах.
5. Тайлагналтыг хугацаанд нь оновчтой, шалгуур үзүүлэлтийн дагуу 2000 тэмдэгтэд багтаан, тодорхой тайлагнаж хэвших.
6. Хэлтийн дарга нар Нийслэлийн Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн I, II улиралд хийсэн хяналт-шинжилгээний дүн, зөвлөмжийг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллаж байх.

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**  
**ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

**Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2025 оны гүйцэтгэлийн  
төлөвлөгөөний 70 хүртэл хувийн хэрэгжилттэй ажил**

1. Нийтийн эрүүл мэндийн өвчний хяналт, сэргийлэлтийн хэлтэс
  - 2.9. Товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчний тохиолдлыг бууруулна
2. Эмнэлгийн тусламжийн хэлтэс
  - 2.14. "Эхээс урагт дамжих гурвалсан халдвар"-ыг бууруулах, ургийн гажиг эрт илрүүлэх боломжийг бүрдүүлж, жирэмсний эрт хяналтыг нэмэгдүүлнэ.
3. Төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
  - 3.9. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай хийлгэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.
4. Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтэс
  - 5.2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхэд хууль, зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэх, хариуг албан ёсоор өгч хэвших, өргөдөл, гомдлын хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулна.